

ОЛОН НИЙТЭД СУУРИЛСАН ГАЛ УНТРААХ БАГИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ш.Мөнгөнтуяа¹, Ч.Нямхүү²

*^{1,2}Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж,
Монголын улаан загалмай нийгэмлэг*

Цахим шуудан: nyamkhuu.ch@redcross.mn

Хураангуй: Аймаг, орон нутгийн онцлогтой уялдуулж гамшгийн эрсдэлийг бууруулах замаар олон нийтийн гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх тус төслийн зорилтын хүрээнд суманд Гал унтраах баг байгуулах, тус багийг шаардлагатай багаж хэрэгслээр хангах, багийн гишүүдийг сургалт, Онцгой байдлын албаны гамшгаас хамгаалах хүний нөөцийн чадавхад хэрхэн дэмжлэг үзүүлж байгаа болон гал унтраах багийн тогтвортой үйл ажиллагааг хэрхэн хангах тухай зөвлөмжийг боловсруулахад энэхүү судалгааны ажлыг зориулсан болно.

Түлхүүр үг: Гал түймэр, сайн дурын бүлэг, гал унтраах баг, онцгой байдлын алба, орон нутгийн удирдлага, улаан загалмай.

Оршил

МУЗН нь эмзэг байдалд байгаа иргэдэд Хөдөлгөөний үндсэн зарчмуудыг баримтлан хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээг хүргэдэг, төрдөө нэмэлт хүч болж ажилладаг Хүмүүнлэгийн байгууллага юм.

Тус байгууллага нь иргэдийн амь нас, амьжиргааг аливаа гамшиг, ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах, нөхөн сэргээх үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

МУЗН нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрхзүйн байдлын тухай хуулийн хүрээнд иргэд, олон нийтийн гамшгийн даван туулах чадавхыг бэхжүүлэх, онцгой байдлын байгууллагад өөрийн үйл ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэх, гамшигт нэрвэгдсэн иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үүрэгтэй юм.

Өмнө дурьдсан төслийн хүрээнд байгуулагдсан сумын түвшний гал унтраах баг нь орон нутгийн гамшгаас хамгаалах хүчин чадал, иргэдийн оролцоонд суурилсан нь гамшгаас хамгаалах орон нутгийн хүчин чадлыг тогтвортой хөгжүүлэх зорилготой юм. Төслийн үйл ажиллагаанд орон нутагт суурилсан гамшигтай тэмцэх баг баг, гал түймэртэй тэмцэх баг байгуулагдсан ба шаардагдах тоноглол, хэрэгслээр хангагдсан юм. Энэхүү судалгааны ажлын

Судалгааны материал, арга зүй

Судалгааны ажлын хүрээнд [хүснэгт 1](#)-т заасан арга, аргачлалыг ашиглан анхдагч болон хоёрдогч мэдээллийг цуглуулан, мэдээлэлд дүн шинжилгээ хийж гал түймэртэй тэмцэх багийн үйл ажиллагааны тогтвортой байдал, үйл ажиллагаанд шинжилгээ хийсэн болно.

```
graph TD; A[Үе] --> B[Мэдээлэл цуглуулах]; B --> C[Мэдээлэл боловсруулах]; C --> D[Төслийн үр ашиг, ач холбогдол, тогтвортой байдалд өгсөн үнэлгээ, төслийн үйл ажиллагаанд анхаарах зөвлөмж]; B --> E[Баримт бичиг судлах -  
1. бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө  
2. хууль, дүрэм, журам, заавар, стандарт, санамж бичиг, гэрээ  
...  
Бүлгийн ярилцлага -  
1. Улаан загалмай дунд ба анхан шатны хороо, сумын удирдлага, орон нутгийн онцгой байдлын байгууллагын ажилтан  
2. Гал унтраах сайн дурын баг  
Ганцаарчилсан ярилцлага -  
1. Гал унтраах сайн дурын багийн гишүүд  
Асуулга -  
1. Гал унтраах сайн дурын багийн гишүүд  
2. Улаан загалмай дунд шатны хорооны ажилтан  
Ажиллалт -  
1. гал түймэр унтраах багаж хэрэгсэл  
2. тусгай тоноглол, нэг бүрийн хэрэгсэл]; E --> F[Агуулгын шинжилгээ  
SWOT шинжилгээ  
Хоёрдогч мэдээлэл шинжлэх]; F --> D;
```

Үе

Мэдээлэл цуглуулах

Мэдээлэл боловсруулах

Арга

Баримт бичиг судлах -

1. бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө
2. хууль, дүрэм, журам, заавар, стандарт, санамж бичиг, гэрээ
- ...

Бүлгийн ярилцлага -

1. Улаан загалмай дунд ба анхан шатны хороо, сумын удирдлага, орон нутгийн онцгой байдлын байгууллагын ажилтан
2. Гал унтраах сайн дурын баг

Ганцаарчилсан ярилцлага -

1. Гал унтраах сайн дурын багийн гишүүд

Асуулга -

1. Гал унтраах сайн дурын багийн гишүүд
2. Улаан загалмай дунд шатны хорооны ажилтан

Ажиллалт -

1. гал түймэр унтраах багаж хэрэгсэл
2. тусгай тоноглол, нэг бүрийн хэрэгсэл

Агуулгын шинжилгээ

SWOT шинжилгээ

Хоёрдогч мэдээлэл шинжлэх

Үр дүн

Төслийн үр ашиг, ач холбогдол, тогтвортой байдалд өгсөн үнэлгээ, төслийн үйл ажиллагаанд анхаарах зөвлөмж

Судалгааны ажлын хүрээнд төслийн тогтвортой байдалд:

- Бодлого, эрх зүйн орчны хүчин зүйл;
- Санхүүгийн хүчин зүйл;
- Нийгэм, хувь хүний хүчин зүйл;
- Хүрээлэн буй орчны хүчин зүйл хэрхэн нөлөөлөхийг авч үзсэн.

Төслийн тогтвортой байдалд нөлөөлөх 4 хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлт тус бүрээр 1-3 онооны үнэлгээг өгөхдөө 2-р хүснэгтэд үзүүлсэн байдлаар тооцсон.

2-р хүснэгт. Төслийн тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлсэд өгсөн чанарын үнэлгээ

Хүчин зүйлийн нэр	Жингийн утга	Хэмжээслэл	Харгалзах оноо	Тогтвортой байдалд нөлөөлөх түвшин
Бодлого, эрх зүйн орчны хүчин зүйл	30%	Үйл ажиллагааны чиглэл муу тусгагдсан	3	Их
		Үйл ажиллагааны чиглэл дунд тусгагдсан	2	Дунд
		Үйл ажиллагааны чиглэл сайн тусгагдсан	1	Бага
Санхүүгийн хүчин зүйл	30%	Санхүүгийн эх үүсвэр зайлшгүй шаардлагатай	3	Их
		Санхүүгийн эх үүсвэрийн шаардлага дунд зэрэг	2	Дунд
		Санхүүгийн эх үүсвэр шаардахгүйгээр үргэлжлэх боломжтой	1	Бага
Нийгэм, хувь хүний хүчин зүйл	30%	Шууд хамааралтай	3	Их
		Бага хамааралтай	2	Дунд
		Хамааралгүй	1	Бага
Хүрээлэн буй орчны хүчин зүйл	10%	Шууд хамааралтай	3	Их
		Бага хамааралтай	2	Дунд
		Хамааралгүй	1	Бага

Хүснэгт 3. Төслийн тогтвортой байдлын чанарын үнэлгээний онооны тайлбар

Тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлд харгалзах чанарын үнэлгээ	Бага буюу тогтвортой үргэлжилнэ	Дунд буюу тогтвортой эсэх нь эргэлзээтэй	Их буюу тогтвортой үргэлжлэх боломжгүй
Тогтвортой байдлын индекс	1-1,5	1,6-2,0	2,0-2.8

Экспертүүд төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлын чанарын үнэлгээний индексийг дараах томъёог ашиглан тодорхойлов.

$$S_i = \sum X_i * W_i \quad [1]$$

энд: $i = 1 \div n$

X_i –*идүгээр factor буюу нөлөөлөх хүчин зүйл*

W_i – *идүгээр factor буюу нөлөөлөх хүчин зүйлийн жигнэгдсэн утга*

S_i – *Тогтвортой байдлын индекс*

Төслийн 4 үйл ажиллагаа тус бүрийн тогтвортой байдлыг өмнө тайлбарласан аргачлалыг ашиглан 4-р хавсралтанд үзүүлсэн байдлаар үнэлж үр дүнг Хүснэгт 4-д харуулав.

Хүснэгт 4.Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдалд өгсөн экспертийн үнэлгээ

Чадавхад нөлөөлж буй үзүүлэлт	Бодлого, эрх зүйн орчин	Санхүүгийн хүчин зүйл	Нийгэм, хувь хүний хүчин зүйл	Хүрээлэн буй орчны хүчин зүйл	Тогтвортой байдлын индекс (S_i)
Аймгийн улаан загалмайн дунд шатны хороо, Онцгой байдлын газрын хамтын ажиллагаа;	1	2	2,5	-	1,81
Гамшигтай тэмцэх сайн дурын багийг чадавхжуулах	1	1,5	1,78	1	1,38
Сумын сайн дурын гал унтраах багийг чадавхжуулах	1	1,5	1,5	3	1,5
Малчин өрхийг чадавхжуулах	2	2	1.5	2	1,91

Эндээс үзэхэд “Аймгийн улаан загалмайн дунд шатны хороо, Онцгой байдлын газрын хамтын ажиллагаа”-д **нийгэм, хувь хүний хүчин зүйл**, “Гамшигийн үед ажиллах сайн дурын багийг чадавхжуулах” үйл ажиллагаанд мөн **нийгэм, хувь хүний хүчин зүйл**, “Сумын сайн дурын гал унтраах багийг чадавхжуулах” үйл ажиллагаанд **хүрээлэн буй орчны хүчин зүйл**, “Малчин өрхийг чадавхжуулах” үйл ажиллагаанд **санхүүгийн хүчин зүйл** ихээхэн нөлөөлөх магадлалтай байна.

Тогтвортой байдлын индексийн дарааллаар төслийн үйл ажиллагаа тус бүрийг эрэмбэлж үзэхэд:

Эрэмбэ	Үйл ажиллагаа	Тогтвортой байдлын индекс
I	Гамшигтай тэмцэх сайн дурын багийг чадавхжуулах	1,38
II	Сумын сайн дурын гал унтраах багийг чадавхжуулах	1,5
III	Аймгийн улаан загалмайн дунд шатны хороо, Онцгой байдлын газрын хамтын ажиллагаа;	1,81
IV	Малчин өрхийг чадавхжуулах	1,91

Дээрх эрэмбээс үзэхэд Сумын сайн дурын гал унтраах багийг чадавхжуулах” үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэн хэрэгжих боломжтой байна.

Судалгааны үр дүн

Манай улс 1 сая 566 мянган км² нутаг дэвсгэртэй эдгээр нь 21 аймгийн 330 суманд хуваагддаг. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь аймаг, дүүрэг томоохон сумын төвүүдэд гал унтраах аврах ангитай боловч алслагдсан сум, хороонд төдийлөн хүрч ажиллах боломж хязгаарлагдмал байдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт 48 гал унтраах аврах анги байгаагаас Улаанбаатар хотод байрлах гал унтраах ангийг эс тооцвол аймгуудын төв, томоохон сумын төвүүдэд нийт 37 гал унтраах үйл ажиллагаа явуулж байна. Бусад 293 суманд гал түймэр унтраах аврах анги байхгүй байгаа нь сумын төвд гал түймэр гарсан тохиолдолд хохирол их дагуулахад хүргэдэг. Тухайлбал Сэлэнгэ аймаг нь 17 сумтайгаас 2017 онд объектын гал түймэр нийт 99 удаа гарснаас аймгийн төвөөс алслагдсан сум болох Алтанбулаг суманд – 5, Цагааннуур суманд – 1, Шаамар суманд – 4, Сайхан суманд – 10, Сант суманд – 1 удаа, Хүдэр суманд – 1, Ерөө суманд – 1 удаа тус тус гал түймэр гарч 150 сая төгрөгийн хохирол учруулсан байна(ОБЕГ, 2017).

Судалгааны ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2017 онд гарсан 5 удаагийн ой, хээрийн түймрийн 2-д нь багийн гишүүдийг дайчлан ажиллуулсан нь уг түймрийг хохирол багатай унтраахад ихээхэн хувь нэмэр оруулсан гэдгийг Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын ажилтнуудтай хийх ярилцлагын үед онцолж байсан. Мөн Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газрын удирдлагуудтай хийсэн уулзалтын үед байгууллагын удирдлагууд “Гал түймрийн голомтод ажилласан гал унтраах сайн дурын багийн гишүүд нь энгийн иргэдтэй харьцуулбал унтраах үйл ажиллагаанд оролцох оролцоо сайтай, туршлага онолын мэдлэг сайтай байсан” талаар онцлон тэмдэглэж байв.

Аймгийн төвөөс алслагдсан сумын төвийн засаг даргын тамгын газрыг түшиглэн “Гал түймэр унтраах баг”-ийг засаг даргын захирамжаар байгуулсан нь дор дурьдсан хэд хэдэн чиглэлд ач холбогдолтой байна гэж үзлээ.

Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хуулийн 10.2 -р зүйлд гал түймэртэй тэмцэх нэгжийн зохион байгуулалтыг тусгаж өгсөн ба энэхүү заалтын 4-р хэсэгт сумын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг зааж өгсөн байна. Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг нь орон нутгийн санаачилгаар сайн дурын үндсэн дээр нэгдэж объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг унтраах чиг үүргийг хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлэхээр байгуулагдана гэж заагдсан байна.

Галын аюулгүй байдлыг хангах дээрх хуулийн хэрэгжилтийг хангахад сумын төвүүдэд байгуулсан гал унтраах баг нь ихээхэн дэмжлэг үзүүлэх нь зайлшгүй юм.

Дээрх хуулийн заалтаар сумдад байгуулсан гал түймэртэй тэмцэх багийг зохион байгуулж болох бөгөөд цаашлаад 10.3-р зүйлд гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ажиллуулах боломжийг бүрдүүлж өгчээ. Хуулийн 14.1-р зүйлд сайн дурын гишүүн нь гал түймэр унтраах чиг үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон, амь насаа алдсан тохиолдолд онцгой байдлын албан хаагчийн нэгэн адил тэтгэвэр, тэтгэмж олгогдохоор заагдсан байна. Мөн түүнчлэн хуулийн 15.1.4-д Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг даргын үүрэгт нутаг дэвсгэртээ гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн болно. Мөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/346 тоот тушаалаар “Гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журам”-ыг батлуулсан байна.

Дээрх журмаар гал унтраах сайн дурын хэсэг буюу гал унтраах багийн гишүүдийн ажиллах нөхцлийг хангах зорилгоор санхүүгийн дэмжлэгийг тусгаж өгсөн ба жишээлбэл сайн дурын багийн ахлагч нь сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, харин багийн гишүүд болох жолооч, гал сөнөөгч нар нь улиралд нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тус тус цалинжина гэж заагдсан байна. Ингэхдээ хэсгийн дарга -1, жолооч -1, гал сөнөөгч 4 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй байх ба тухайн иргэд нь 18-60 насны тухайн орон нутагт байнга оршин суудаг, хэсгийн дарга нь мэргэжлийн сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна гэж заасан байна. Гал унтраах сайн дурын хэсгийн ажиллах техник хангамжийг энэхүү журмаар тогтоосон ба журмын 10.1-д зааснаар сайн дурын хэсэг нь гадаад улс орон, төрийн бус байгууллага, олон улсын

байгууллагын хандив тусламж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж шаардлагатай материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдаж болно гэж заасан байна.

МУЗН-ийн Гамшгаас хамгаалах тухайхуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүрээнд:

- МУЗН нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт хүч болон ажиллах чиг үүргээ хэрэгжүүлэх, сумын түвшний гал унтраах багийн гал түймэртэй тэмцэх чадавх нэмэгдэж байгаагаараа ач холбогдолтой байна.

Сумдын гал түймэртэй тэмцэх чадавх сайжрах хүрээнд:

- Аймгийн төвийн гал унтраах аврах ангиас алслагдсан сумын төвд объектын гал түймэр гарсан тохиолдолд иргэд харж байгаад өөрийн гэр орноо шатаалгах, цаашлаад гал түймэр тархаж олон гэр орон сууцыг хамрах аюултай байдаг. Тиймээс төсөл хэрэгжснээр объектын гал түймрийг өөрсдийн хүчин чадлын хүрээнд унтрааж учрах хохирлыг багасгах боломж бүрдэж байна.

Галын аюулгүй байдлын тухай хуулийг орон нутагтаа хэрэгжүүлэх сумын засаг дарга төслийн үйл ажиллагаагаар дамжуулан багийн гишүүдийг МУЗН, ОББ-ын дэмжлэгтэйгээр сургаж дадлагажуулсан, орон нутгийн хэмжээнд гарсан гал түймрийг унтраах анхан шатны багаж хэрэгсэлтэй болсон нь ихээхэн ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Сумын хэмжээнд гарсан объектын болон ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд оролцохдоо урьд нь ямар нэгэн багаж хэрэгсэл тоног төхөөрөмжгүй байсан бол төсөл хэрэгжсэнээр унтраах үйл ажиллагаанд гарах хүндрэл тодорхой хэмжээгээр буурсан байна.

Багийн гишүүд нь төслийн хүрээнд 2-3 удаа сургалтанд хамрагдаснаар объектын болон ой, хээрийн түймрийн шаталтаас үүсэх бүтээгдэхүүн болох утаа, дулааны нөлөөнд өртөхгүй байх, өөрийгөө болон бусдыг аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц болжээ.

Мөн тайван цагт гал түймэр унтраах усан хөөргийг ашиглан зүлэг, ногоо услах, малын гаралтай өвний үед ариутгалын бодис цацах арга хэмжээнд ашиглах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Гал унтраах багийн гишүүдийн хувьд:

- Галын аюулгүй байдлын тухай хууль, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажиллах журамд урамшууллын талаартусгагдсан талаар ямар

нэгэн ойлголт байхгүй ньбагийн гишүүдээс авсан асуулгаас харагдсан. Иймд цаашид багийг ажиллах нөхцлөөр хангахын тулд тодорхой хэмжээний урамшууллын систем хэрэгтэй байгааг багийн гишүүдэд тайлбарлаж өгсөн.

- Сумын хэмжээнд гарсан объектын болон ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд оролцохдоо урьд нь ямар нэгэн багаж хэрэгсэл тоног төхөөрөмжгүй байсан бол төсөл хэрэгжсэнээр ямар нэгэн хэмжээгээр унтраах үйл ажиллагаанд гарах хүндрэл багассан.

Багийн гишүүд нь төслийн хүрээнд 2-3 удаа сургалтанд хамрагдсан нь гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээний дэмжлэг болж байгаа нь харагдаж байна.

Объектын болон ой, хээрийн түймрийн шаталтаас үүсэх бүтээгдэхүүн болох утаа, дулаан зэрэг нь иргэдэд аюул учруулж үхэлд хүргэх боломжтой тиймээс багийн гишүүд нь сургалтанд хамрагдсанаар гал түймрийн үед хэрхэн ажиллах, сандралд өртөлгүй өөрийгөө болон бусдыг аврах ажилд хэрхэн туслах талаар тодорхой хэмжээний мэдлэг олж авсан ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Аймгийн төвөөс алслагдсан сумын төвд гал унтраах баг байгуулсан нь “Галын аюулгүй байдлын тухай хууль”-д заагдсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах хуулийн хэрэгжилт хангагдахаас гадна орон нутагт гал түймэр гарсан тохиолдолд өөрийн хүч бололцоонд тулгуурлан унтрааж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж буй томоохон алхмуудын нэг юм. Аймгийн улаан загалмайн дунд шатны хороо, Онцгой байдлын байгууллагатай хамтран гал унтраах багийн гишүүдэд заасан сургалт үр дүнтэй болж гишүүд тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон нь гишүүдээс авсан гал түймэр унтраах онолын мэдлэгийг шалгасан (Хавсралт 1) сорилын дүнгээр илэрхийлэгдэж байлаа.

Гал түймэр унтраах багийн гишүүдийн багаж хэрэгслүүд нь тодорхой хэмжээнд ашиглагдахаар байгаа боловч эдгээр багаж, тоног төхөөрөмжийг өвлийн улиралд ашиглах нөхцөл бүрдээгүй, багийн гишүүдийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл байнгын бэлэн байдалд бус, гишүүдийн ажил үүргийн хуваарь тодорхой бус зэрэг дутагдалтай талууд ажиглагдаж байна.

Ашигласан материал

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он.
2. Галын аюулгүй байдлын тухай хууль
3. МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль, 2016 он.

4. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Улсын их хурлын №22 тогтоол, 2011 он.
5. 2015-2030 онд хэрэгжүүлэх Сэндайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг
6. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015-2025
7. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011-2021
8. "Монгол мал" үндэсний хөтөлбөр, 2010-2021
9. МУЗН-ийн Гамшгийн менежментийн хөтөлбөр, <http://www.redcross.mn/b/s/18-13>.
10. МУЗН-ийн Стратеги 2020, <http://www.redcross.mn/a/s/17-102>.
11. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам", Монгол улсын шадар сайдын №34 тоот тушаал, 2016 он.
12. "Төр, улаан загалмайн хамтын ажиллагааны бүрэлдэхүүн, ажиллах журам"
13. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар", ОБЕГ-ын даргын А/185 тоот тушаал, 2016 он.
14. ОБЕГ-ын даргын А/346 тоот тушаал "Гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журам"
15. Ү.Хадбаатар (2015), Малчин өрхийн амьжиргааны судалгаа, ХААИС, Агро экологи, бизнесийн сургууль
16. Аюул, гамшгийн үеийн эмзэг байдал, хүчин чадлын үнэлгээний тайлан 2014
17. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2000-2013
18. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2014, 2016
19. Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл 2004-2016
20. Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, улаан загалмайн хороотой хамтран өвөлжилтөнд бэлтгэсэн ажлын тайлан, 2017 он
21. 2017 дунд шатны хорооны тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн нэгдсэн тайлан
22. Дархан уул аймгийн улаан загалмайн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайлан
23. Дархан уул аймгийн улаан загалмайн хорооноос "Гамшгийн үеийн яаралтай тусламж" төслийн хүрээнд зудад өртсөн дархан сумын малчдын дунд хэрэгцээний үнэлгээ хийсэн үйл ажиллагааны тайлан
24. ОУУЗУХСНХолбоо, Австралийн улаан загалмайн санхүүгийн дэмжлэгтэйгээр "Хөдөө орон нутгийн малчид болон хот суурин газрын гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх" төслийн тайлан, 2017, Сүхбаатар сум

25. ОБГ-аас “Хөдөө орон нутгийн малчид болон хот суурин газрын гамшгийн даван туулах чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, 2016-2017, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь аймаг

26. Санамж бичгийн хүрээнд хийсэн ажлын тайлан 2016-2017 он, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь аймаг

27. Дундговь аймгийн Онцгой байдлын газар, улаан загалмайн дунд шатны хорооны хүмүүнлэгийн чиглэлээр хамтран ажиллах гэрээний дагуу 2017 онд хийгдсэн ажлын тайлан

28. Mongolia- CBDRR Mid Term Review (MTR), Australian Red Cross Society, Mongolian Red Cross Society and IFRC Mongolia, 2017

29. Guidance for conducting midterm reviews of Undp-supported, Gef-financed projects, UNDP-GEF Directorate, 20146

30. <http://www.nema.gov.mn>

31. <http://www.1212.mn>

32. <http://www.redcross.mn>

33. <http://darkhan.gov.mn/>

34. <http://selenge.gov.mn>

35. www.dundgovi.gov.mn